

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2026 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-25

1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/	4-25
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны ээлжит бус чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 09 дүгээр сарын 10-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 40 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Амарбаясгалан, Ж.Бат-Эрдэнэ, А.Ганбаатар, Т.Доржханд, С.Зулпхар, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаатар, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Б.Жавхлан, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ө.Шижир.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2026.08.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд С.Даваасүрэн, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Г.Билгүүн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, мөн зөвлөлийн гишүүн А.Энхбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн зөвлөлийн Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Гантулга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Мягмар, мөн хорооны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаа, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Оюунгэрэл, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Л.Ичинноров, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Г.Гантулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргааны удирдлага, хүний нөөцийн газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, мөн газрын Санхүү, хангамжийн хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Б.Мөнх-Оргил, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Үндэсний

аюулгүй байдлын зөвлөлийн Санхүүгийн хэлтсийн дарга Х.Отгонжаргал, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Стандарт, хэмжил зүйн газрын дарга Х.Батжаргал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбадрах, Ёс зүйн хорооны Ажлын албаны дарга Н.Ганбаатар, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Төгөлдөр, Төрийн захиргааны удирдлагын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Н.Цэвэлмаа, мөн газрын аудитын менежер И.Эрдэнэцэцэг, ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хорооны асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ц.Баянмөнх, зөвлөх Г.Алтанцэцэг, Б.Баярсайхан, референт Б.Баясах, Т.Нарантунгалаг, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Э.Болормаа, Б.Хэрлэн, Б.Батбаатар нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, Монгол Улсын ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Ж.Дэлгэрсайхан, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга Н.Мягмар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Улсын Их Хурлын Тамгын газрын Санхүү, хангамжийн хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Л.Эрдэнэбадрах нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа, О.Алтангэрэл, Б.Батбаатар нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 15 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 53.1 хувийн ирцтэйгээр 15 цаг 55 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.ЖАВХЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 09 дүгээр сарын 10-ний өдөр,

Лхагва гараг Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим 14 цаг 40 минут

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ч.Ундрам: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 56.3 хувьтай бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2026 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал нэг. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн, 2 дахь хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орно оо.

Хэлэлцэх асуудал. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн далдугаар зүйлийн 70.1-д төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгээр Төсвийн болон бусад байнгын хороо төсвийн төсөлтэй танилцаж хуралдаанаар хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцэнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Ж.Энхбаяр. Сайд орж ирэх юм уу? Алга байна. Төрийн албаны зөвлөлийн дарга Цэдэвсүрэн ирсэн байна. Монгол Улсын ерөнхий аудитор Магнайсүрэн. Түрүүн гадаа явж байсан ороод ирэх юм байна. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Мягмар ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Дэлгэрсайхан ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Даваасүрэн. Дуудуулаарай Даваасүрэн сайдыг. Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Билгүүн ирсэн байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Энхбат байхгүй байна. Ирсэн байна уу? Сонгуулийн ерөнхий хорооны Санхүүгийн хэлтсийн дарга Оюунгэрэл ирсэн байна. Энэ Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү дарга ирчихсэн юм уу? Ирээгүй байна шүү дээ. Сангийн яамны ТНБД-ын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч Санжаадорж ирчихсэн байна, Улсын Их Хурлын Тамгын газрын санхүү хангамжийн хэлтсийн дарга Лхагвасүрэн ирсэн байна. Энэ байгаа. ҮАБЗ-ийн Санхүүгийн хэлтсийн дарга Отгонжаргал, Ёс зүйн хорооны ажлын албаны дарга Ганбаатар, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Захиргаа, удирдлагын газрын дарга Гантулга тэр байна. ЗГХЭГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Гантуяа, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Мөнх-Эрдэнэ, Эдийн засаг, хөгжлийн яамны хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Төгөлдөр, Сангийн, яамны Татварын бодлогын газрын дарга Чимидсүрэн тэр байна. Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Тулга, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Ичинноров, ОБЕГ-ын дарга Ариунбуян ирсэн байна. Онцгой байдлын ерөнхий ерөнхий газрын Санхүү, ар талын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Мөнх-Эрдэнэ, СХЗГ-ын дарга Батжаргал, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Мөнх-Оргил, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Энхтуул, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэлмаа, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитын менежер Эрдэнэцэцэг, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын аудитын менежер Анхбаяр, Үндэсний аудитын газрын Тусгай чиг үүргийн аудитын газрын Аудитын менежер Цэгмэддорж, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Гантулга, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга Мягмардорж, Эдийн засаг, хөгжлийн яамны ТЗУГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга Гэрэлбат, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Гантогтох, НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Эрдэнэбадрах, Сангийн сайд Мэндсайхан ирчихсэн байна. Монголбанк ирчихсэн юм биш үү? Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч Анар ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн далдугаар зүйлийн 70.2-т Байнгын хорооны хуралдаанд гишүүд тухайн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч Монгол Улсын ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж үг хэлж болно оо гэж заасан байна.

Тэгэхээр та бүхэн энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух бол нэрсээ өгнө үү? Хэрлэн гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Ямар ч байсан Мэндсайхан сайд ашгүй амжаад ороод ирлээ.

Яг нэг ч сайд байхгүй байна. Хэнээс энэ төсвийг асуух юм бэ гэж асуух гэж байлаа. Ер нь төсөв төсвийн тодотголыг хэлэлцэж байхад энэ яамдын мэргэжлийн хүмүүс маань нэлээд солигдчихсон асуудлаа мэддэг яг хариулчихаар хүмүүс ч гэсэн их хомс харагдаад байх юм.

Төрийн албаны зөвлөлийн даргаас асуумаар байна. Төрийн албаны тухай хууль мөрдөгдөж байна уу, түр орлон гүйцэтгэгч хэчнээн тавигдсан бэ? Ер нь ковидын үед яах вэ бид нар сонгон шалгаруулалтаа энэ шалгалтаа зохион байгуулах боломж хомс байсан учраас түр орлон гүйцэтгэгчээр томилоод болоод байсан. Тэгээд тэр чинь зөвхөн ковидын үед л уг нь түр зуурын арга хэмжээ байсан.

Тэгээд одоо болохлоор бүүр хавтгайрчихлаа. Бүх яаман дээр оччихлоор бүх газар нь бүгд ер нь түр орлон гүйцэтгэгч маш олон байх юм. Энэ тал дээр Төрийн албаны зөвлөл зөвлөмж өгч байна уу үгүй юу? Яг энэ төрийн албаны тухай хуулийн хэрэгжилт нь хэр байгаа бол? Энэ нэгдсэн бодлого ер нь маш хүнд харагдаад байна. Ялангуяа би бол энэ цалин хөлсний нэгдсэн бодлого дээр төрийн албаны нэгдсэн бодлого дээр үнэхээрийн санаа зовниж байна. Төрийн албаны зөвлөл дээр нэг төрийн албан хаагчийн хууль дээр нэг санал санаачилга яваад байсан санаж байна. Баатарзориг даргын үед. Төрийн үйлчилгээний алба яах вэ гээд асуудал яригдаж байсан. Одоо эрүүл мэндийн салбар боловсролын салбар дээр маш хүнд. Боловсролын салбар бол яах вэ? Цалин хөлсийг нь ингээд төсвөөс тавиад яваад байна. Эрүүл мэндийн салбар, ЭМД-ын санд ачааллыг нь үүрүүлчхээд тэгсэн мөртөөсөө ингээд л нэг төрийн албан хаагч гээд л ингээд дотор нь ийм нэлээд холилдоод нэг хүнд болчихоод байна л даа.

Тэгээд энэ алдаануудыг хэн засах вэ? Хэзээ зориглож хийх вэ? Хэн ер нь хариуцах вэ гэдэг ер нь л их тийм бүрхэг болоод байна аа. Тэгээд Төрийн албаны зөвлөл дээр яг одоо төрийн албаны тухай хууль хэр мөрдөгдөж байна вэ? Хэчнээн түр орлон гүйцэтгэгч байна вэ? Яамдын халаа сэлгээ ямар нөхцөл байдалтай байна вэ гэдэг мэдээлэл ер нь байна уу байхгүй юу?

Ч.Ундрам: Нэг номерын микрофон. Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөл хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Энэ талаарх тайлан мэдээллүүдээ Улсын Их Хурал болон Байнгын хороондоо танилцуулаад явж байгаа. Түр орлон төрийн жинхэнэ албан хаагчийг түр орлон гүйцэтгэх төрийн албаны хуульд 10 үндэслэл байдаг, 10 үндэслэл. Ээлжийн амралттай үед нь түр орлон гүйцэтгэдэг. Хүүхдээ харж байгаа асарч байгаа болон жирэмсний болон декреттэй амралттай үед, 3 сараас нэг жилийн хугацаанд хэрвээ өвдөх юм бол, 6 сар хүртэлх хугацаанд сургалтад хамрагдана, 2 жилийн магистрт сурах гээд ингээд ийм 10 үндэслэл байдаг. Энэ түр орлонгууд бол хуульд заасан түр орлон гэж үздэг. Бид нар энэ чиглэлээр зөндөө ажил хийдэг. 2024, 2025, 2026 оны өнөөдрийг хүртэлх хугацаанд олон төрлийн судалгаанууд авч хяналт шалгалтуудыг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэрээр хэрэгжүүлж аудитыг хэрэгжүүлээд ажиллаж байна.

Хамгийн сүүлд 2026 оны 8 сарын 31-ний өдрийн байдлаарх эцсийн судалгааг сая ер нь түр орлон гүйцэтгэгчүүд ямар хэмжээтэй байна гэдэг судалгаагаа авч үзлээ. Яагаад судалгаа хийсэн бэ гэхээр бүх яам 20 агентлагт хүний нөөцийн аудит хийсэн. Аудитын зөвлөмжийн биелэлт ямар байна мөн 2025, 2026 онд хийсэн хууль хэрэгжилтийн хяналт шалгалтын хэрэгжилт ямар байна вэ гэдгийг үзэхийн тулд энэ судалгааг хийж үзлээ. Яг өнөөдрийн байдлаар 8 сарын 31-ний дүнгээр 2398 түр орлон гүйцэтгэгч ажиллаж байна. Төрийн байгууллагуудад. Үүнээс 1481 нь одоо саяын миний хэлж байгаа Төрийн албаны хуулийн 42 дугаар зүйлд заасан 10 үндэслэлээр түр орлон гүйцэтгэгч ажиллаж байна. Хууль бус буюу одоо бид нарын хэлж байгаагаар тусгай шалгалтгүй, яг хуульд заасны дагуу дотроос нь байгууллага дотроос түр орлон хийгээгүй 900 албан тушаалтан ажиллаж байна. 900 албан тушаалтныг яагаад ингээд тоо ингэж өөрчлөгдөөд гарчхав гээд үзлээ. Төрийн албаны зөвлөл 2025, 2026 онд хүний нөөцийн аудит хяналт шалгалтуудыг ойролцоо дүнгээрээ нэг 30, 40 гаруй мянган төрийн албан хаагч, төрийн жинхэнэ албан хаагчийг хамруулж хийсэн. Хяналт шалгалтынхаа дагуу гарсан шийдвэрүүдээ буцаагаад зөв хэрэгжиж байна уу гэдэг дээр дахин дахин хяналт тавиад ажиллаад

байдаг. Яг хяналт шалгалтын дагуу шийдвэрүүдийг төрийн байгууллагуудад хэрэгжүүлээд буцаад эргээд харахаар дахиад бал баахан бүтцийн өөрчлөлт баахан байгууллагуудын нөгөө бүтэц зохион байгуулалтын хөдөлгөөн хийгдсэнээс болж зарим түр орлонгуудын асуудлууд үүсээд байна аа.

Энэ дээр ганцхан хянан шалгалт хийгээд орхичихдоггүй. ЗГХЭГ, бүх сайд нар, Засаг дарга нарт хуульд заасны дагуу чиглэл, зөвлөгөө, зөвлөмжүүдийг бол 2025, 2026 оны өнөөдрийн байдлаар бид нар 100 гаруйг хүргүүлчихжээ.

Ч.Ундрам: Нэг минут өгье гүйцээж хариулъя. Тэгээд бас энэ цалин хөлсний нэгдсэн бодлогыг хэн хариулах юм? Нэг номер, нэмж минут өгье.

Л.Цэдэвсүрэн: Тэгэхээр энэнийхээ хойноос манай байгууллага тасралтгүй ажиллаж байна, алдаа засаж байна, буцаад гарч ирж байна. Дахиж алдааг засах ажлуудыг тасралтгүй хийж байгаа. Бүтэц, зохион байгуулалтын хөдөлгөөн үнэндээ манай байгууллагын чиг үүрэгт маш их хүндрэл учруулж байгааг хэлэх нь зүйтэй гэж бодож байна.

Хоёр дахь нь төрийн албан хаагчийн цалин хөлсний энэ нэгдмэл эрх зүйн байдлыг бий болгож цалин хөлсний зөв тогтолцоо руу оръё гэдэг саналыг 2023 оноос хойш Засгийн газар болон холбогдох Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүсэлт тавьсны дагуу хэд хэдэн хуулийн төсөл боловсрогдоод яг одоо хамгийн идэвхтэй боловсрогдож байгаа хуулийн төсөл маань энэ байна. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг гараад энэ дээр манай байгууллага хамтраад ажиллаж байна.

Төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгааны хуулийн төслийг Засгийн газар бол хэзээ хэзээгүй өргөн барих болов уу гэсэн ийм итгэл байна. Бид нар энэ дээр хамтарч ажиллаж байгаа.

Ч.Ундрам: Тодруулах уу? Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Алдаа гарсныг илрүүлээд тэгээд зөвлөмж өгөөд зогсох биш тэр алдаа гаргасан хүмүүс алдаагаа давтаад байгаа бол тэр хүмүүст хариуцлага тооцох тал дээр анхаарч ажилламаар байна аа. Тэгэхээр хариуцлага тооцох асуудлыг танайх хийдэггүй юм гэхэд энэ ТББХ-нд саналаа ирүүлээд тэгээд Улсын Их Хурлаас ямар тогтоол байдаг юм энэ асуудлуудаа яримаар байгаа байхгүй юу. Энэ чинь ердөөсөө дорвитой асуудал улам ингээд муудаад байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр сайн ажилламаар байна, нэг.

Хоёр дахь нь болохоор энэ төрийн албан хаагчдыг ялгаварлаж цалин хөлсийг нэмэгдүүлж байгааг бас анхаармаар байна. Ажлын байрны зураг авалт хийсэн бол бүгдийг нь ижил тэгш гэж одоо бол бүүр ингээд хөрөөний энэ юу шиг бүүр маш замбараагүй болчихсон байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг нэг цэгцэлье ээ. Тэгээд цэгцлэхийн тулд яах вэ гэхээр.

Ч.Ундрам: Нэмж нэг минут авах уу? Ариунзаяа гишүүнд нэг минут өгье.

А.Ариунзаяа: Цалин хөлс нь нэмэгдээгүй байгаа төрийн албан хаагч дээрээ зөв зохистой хэдэн хувиар энэ 80 тэрбум төгрөгийг хуваарилж болох вэ гэдэг тооцооллыг хиймээр байгаа байхгүй юу. Тэгээд энэн дээр Төрийн албаны зөвлөл,

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам суугаад зарим төрийн албан хаагчдыг хагас жилийн хугацаанд огт цалин хөлсийг нь нэмэгдүүлэхгүй заримыг нь болохлоор 50 хувь нэмэгдүүлнэ тэгээд яагаад 50 хувь нэмэгдүүлэх юм бэ гэхээр өөр бусад төрийн албан хаагчдыг 50 хувь нэмэгдүүлчихсэн учраас гээд энэ давхар давхар цаанаа хохироод байгаа хүмүүс маш их байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ажлын ачааллыг нь хараад яг ямар болчихсон юм бэ гэдгийг нь хараад аль албан хаагч дээр нь 20 хувь нэмэх юм, аль дээр нь 10 хувь нэмэх юм. Энэ дунд нь нэг зохицуулалт хийж болмоор харагдаад байгаа байхгүй юу.

Цалин хөлс нь нэмэгдээгүй хүмүүсийг нийтлэгээр нь нэмэх юм бол төрийн албан хаагчдад одоо нэг 8 хувийн нэмэгдэл энэ он дуустал өгч болохоор тооцоолол байна лээ.

Ч.Ундрам: Санал хэллээ. Болормаа гишүүн асуултаа асууя.

Э.Болормаа: Бүгдээрэнд нь өдрийн мэнд хүргэе. Би нөгөө гадаад зээллэг дээр дахиад нэг тодруулаад Сангийн сайдаас болон Сангийн яамнаас яг тодорхой мэдээлэл асууя гэж бодож байна. Бид нар гадаад зээллэгийн хэмжээг таазыг нэмэгдүүлж байгаа гэж ойлгож байгаа. Өнгөрсөн Байнгын хорооны хуралдаан дээр болохоор Сангийн яамны 2 өөр мэдээлэл өгсөн л дөө. Нэг нь энэ 2 их наядаар энэ таазаа нэмэгдүүлж байгаа нь Азийн хөгжлийн банкны кредит лайныг ойлгож байна. Тэр бол гадаад зээллэг учир мөн Улсын Их Хурлын хүрээнд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор орж байна. Нийслэлийн 1 их наядын бонд гэдэг зүйлийг хэлсэн. Тэгэхээр ийм бонд гаргах төлөвлөгөө байгаа юм уу?

Дээрээс нь Санжаадорж дарга миний уул нь яг үндсэн асуулт юу байсан бэ гэхээр энэ газрын тосны боловсруулах үйлдвэр Эрдэнэбүрэн тэгээд Сэлбэ энэ орон сууцжуулалтын төслийг явуулахыг дэмжиж байна. Би тэрийг явуулахын тулд энийг хийгээд байгаа юм болов уу гэж би тийм ойлголттой байсан байхгүй юу. Тэгээд тэрийг хэлэх шиг болсон. Гэтэл энэний зарцуулалт дунд энэ 3 нэрлэгдээгүй учир би энэ 3-ын орон зайг гаргахгүй байгаа юм уу гэдгийг тодруулж асууж байгаа юм. Энийг яагаад онцлоод хэлээд байна вэ гэхлээр энэ төслийг бид нар нэрлээд заахаар ямар зорилготой байна энэ төслийн өөрийнх нь эргэн төлөгдөх чадвар нь хэр юм гэдгээс нь үндэслээд энэний төлөө зээл авах нь зөв гэдэг дээр би санал нэг итгэлтэй байна. Гэхдээ бид нар энэ зээлийн дээд хэмжээгээ, таазаа нэмэгдүүлчихээр нэг өдөр шал өөр хэрэггүй төсөлд энэ зээллэг авчихвал яах вэ? Тэрнээсээ хамгаалах ийм ямар нэгэн механизм оруулсан уу? Тэгэхээр энэ дээр Сангийн яамны байр суурийг асууя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс яг энэ гадаад зээллэгийн дээд хэмжээг нэмэгдүүлсэн дээр та хэд ямар үнэлэлт дүгнэлт хийсэн бэ гэдгийг тодруулъя.

Ч.Ундрам: Мэндсайхан сайд 6 номерын микрофон дээр хариулъя.

З.Мэндсайхан: Болормаа гишүүний асуултад хариулъя.

Хаврын чуулганаар Эрдэнэбүрэн, газрын тос 2-ыг гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах тухай хуулиараа бид нар гаргачихсан. Сэлбэ дэд төв маань үлдчихсэн. Тэгэхээр сая нөгөө төсвийн тодотгол дээр таны асууж байгаа 1 их наядын зардлын орон зай гарч ирж байгаа шүү дээ. Энэ яг таны хэлж байгаа нийслэлийн тэр босгосон Сэлбэ дэд төвийг санхүүжүүлэхийн тулд тэр зардлын орон зайг гаргаж өгч байна гэсэн үг. Бондтой холбоотой асуудлыг нь Тулгаа дарга хариулчих.

Ч.Ундрaм: 9 номерын микрофон өгье.

С.Тулга: Тулгаа Сангийн яам гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. 2026 оны батлагдсан хуулийн 10.10 дугаар зүйл дээр болохдоо Засгийн газрын өр нэмэгдүүлж байгаа хэрэгслийг нэг бүрчлэн тодорхойлж бичсэн байгаа. Батлагдсан хуулийн 10.1 дээр нь дотоод бондын хэмжээ 562 гэж батлагдсан байгаа. Үүний доор Болормаа гишүүний асуугаад байгаа гадаад зээлээр төслийг хэрэгжүүлэх зээлийн дэд хэмжээ нь 1.2 их наяд гэж байгаа. Хавар нөгөө нэг гадаад зээлийн санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх тухай хууль батлагдсан. Үүний дагуу 2026 онд тэр 2 төслийн санхүүжилтээр 1.8 их наяд төгрөг ашиглалт гарна. Энийг төсвийн тодотголд тусгаагүй дүнгээр нь. Яагаад тусгаагүй вэ гэхээр гадаад зээлийн ашиглалтын хуулийн 5.2 дээр энэ 2 төсөлтэй холбоотой гарч байгаа зээлийн ашиглалтаар 2026 оны төсвийн энэ 10.2 дахь заалтыг нэмэгдүүлж болно оо гэж заасан учраас 1.8 нь бол угаасаа ингээд гараад явж байгаа юм. Болормаа гишүүн ээ.

Тэр 10.1 дээр байгаа зээлийн хэмжээг 2 их наяд төгрөг.

Ч.Ундрaм: 9 номер нэмж хариулъя.

С.Тулга: Нэмэгдүүлж байгаа дүнд нь болохлоор 1 их наядын дотоод бондыг нэмж байгаа. Дээрээс нь 200 сая долларын төсвийн дэмжлэг АХБ-аас авах гээд явж байгаа. Үүн дээр нэмээд одоо яг нөгөө нэг АХБ-ны гишүүн орондоо зориулсан энэ эрчим хүч хүнсний хомсдолын үед яаралтай тусламж авах зээлийн шугам нээж байгаа. Энэ дүнгүүд маань тэр 562 дээрээ нэмэгдээд орж байгаа. Таны асууж байгаа гадаад зээ зээлийн ашиглалтын дүн бол тэр 10.2 дахь заалт дээрээ ингээд угаасаа бүх зээлүүд явж байгаа. Үүн дээр газрын тосны дүнг нэмээгүй. Нэмээгүй шалтгаан нь л гадаад зээлийн хуулийн 5.2-оороо энийг нэмэгдүүлэх шаардлагагүй гээд хуульчилчихсан учраас бид нар нэмэгдүүлж бичээгүй ийм л асуудал байгаа.

Ч.Ундрaм: Дэлгэрсайхан даргаас асуусан. 2 номерын микрофон хариулъя.

Ж.Дэлгэрсайхан: Болормаа гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Дэлгэрсайхан. Бид нар Засгийн газрын өр алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд 3 гол зүйлийг онцолсон юм.

Нэгдүгээрт нь өрийн хэмжээ нэмэгдэж байгаа бөгөөд бүтэц нь өөрчлөгдөж байгаа энэ асуудал дээр анхаарал хандуулах шаардлагатай гэсэн ийм зүйлийг дүгнэлтдээ бид дурдсан.

Хоёрдугаарт нь өрийн хэмжээг яг 2026 оны төсвийн тодотгол дээр өмнө нь төлөвлөж байснаас нэлээд хүчтэй өндөр 44.5 хувьд дотоодын нийт бүтээгдэхүүнд хүргэхээр ийм төлөвлөлт хийж байгаа нь бол Засгийн газрын эрсдэлийн түвшнийг нэмэгдүүлж байна гэсэн ийм дүгнэлт дээр бид дурдсан байгаа.

Гуравдугаарт нь энэ өрийг нэмэгдүүлээд байгаа үндсэн шалтгаан маань төсвийн алдагдал санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал орлогын дутагдал мөн юм байна аа. Ийм учраас цаашид энэнтэй холбоотойгоор төсвийн алдагдал санхүүгийн дутагдлыг өрөөр нь нөхөж байгаатай холбоотойгоор ирээдүйд өрийн дарамт

нэмэгдэх ийм боломж байна гэсэн ийм зүйлсийг дүгнэлт дээр бид онцлон анхааруулсан. Баярлалаа.

Ч.Ундрам: Болормаа гишүүн тодруулах уу? Болормаа гишүүн тодруулъя.

Э.Болормаа: Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хэлээд байгаа энэ эрсдэлүүдийг хаах механизм оруулж ирсэн үү? Одоо бид нар нөгөө онцолж төсөл ярихгүйгээр магадгүй нэг өдөр нэг өөр, Ерөнхий сайд өөр, Сангийн сайд ч байна уу өөр энэ газрын дарга нар ингээд сууж байхад өөр Улсын Их Хурлын гишүүд сууж байхад хэн ч байсан хамаагүй бид нар ийм эрсдэлүүдээ хаах механизм оруулж ирсэн үү? Нэгэнт таазаа нэмэгдүүлж байгаа юм чинь хажууд нь эрсдэлээ хаах яг сая Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хэлээд байгаа ийм механизмуудыг бодож оруулж ирсэн үү гэдгийг асууя.

Ч.Ундрам: 9 номер Тулга дарга.

С.Тулга: Тулгаа гишүүний асуултад нэмэлт тайлбар өгье. 2026 оны 2 дугаар эхний хагас жилийн байдлаар ДНБ-д харьцах өрийн хэмжээ ДНБ-ий 35.5 хувь байгаа. Энэ 2026 оны жилийн эцсийн байдлаар энэ 44.5 хувьд хүрнэ гэж бид тооцож байгаа. Энэ тооцоон дотор маань юу ороод явж байгаа вэ гэхлээр мэдээж саяын тодотголоор оруулж байгаа зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа. Үүн дээр нэмээд 1 тэрбум хүртэлх ам долларын Засгийн газрын баталгаа гарч болзошгүй гэдэг энэ дүн маань энэ дотор явж байгаа. Бид Их Хурлаар төсвөө батлуулах тоолондоо баталгаа гаргах эрхээ Их Хурлаас авдаг байгаа. Энэ эрхийг авсны дараа хэрвээ хүсэлт ирэх юм баталгааны тогтоолыг Их Хурал дээр дахиж оруулдаг. Одоогийн байдлаар хүсэлт ирээгүй байгаа. Тэгэхдээ он дуустал ирж магадгүй гэж байгаа учраас 1 тэрбум хүртэлх ам.долларын баталгааны орон зай энэ 44 дотор явж байгаа. 2027 онд өрийн хэмжээ 49.6 болно. Энэ болохлоор 2026 онд 1 тэрбум долларын баталгаа.

Ч.Ундрам: 9 номер нэмж хариулъя.

С.Тулга: Үүн дээрээ нэмээд дахиад 2027 онд 1.6 тэрбум доллар хүртэлх хэмжээтэй Засгийн газрын баталгаа гарна гэсэн энэ төсөөллөөр одоо бид нар 49.6 хувь гэж байгаа. Энэ болохлоор манай төсвийн хүрээний мэдэгдэл дээр батлагдсан 50 хувийн хязгаарт нийцэж байгаа. Өрийн удирдлагын хуулийн өрийн дээд хэмжээ буюу Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өрийн дээд хэмжээ буюу 60 хувьд ингээд нийцээд явж байгаа юм аа.

Ч.Ундрам: Болормаа гишүүн дахиж тодруулъя.

Э.Болормаа: Тулга дарга он дуустал ер нь Засгийн газрын баталгаатай өр авна гэсэн. Магадгүй гэсэн. Та хэд тийм бараг төлөвлөгөө гаргачихсан байгаа юм байна тиймээ? Тийм тооцоолол. Тэгэхээр яг би өчигдрийн Аюулгүй байдлын байнгын хорооноос юу гэж ойлгосон гэхээр Эй Ди Би-ээс тэр төсвийн туслалцаа дэмжлэгийнхээ кред лайнаа ашиглана гэсэн ийм бодолтой байгаа. Тэгэхээр бид нар төсвийн бодохлоор зарлагаа нэмэгдүүлж оруулж ирж байна. Тэгээд зарлагаа хаахын тулд хаанаас зээл авахаа аль хэдийн бодчихсон. Тэгээд тэрэндээ зориулаад зээлийн таазаа нэмэгдүүлээд орж ирж байна гэж ойлгож болох уу?

Ч.Ундрам: 9 номер Тулга дарга хариулъя.

С.Тулга: Сангийн яам Тулгаа. Болормаа гишүүнээ өрийн хэмжээг бид нар дээд хэмжээгээр нь төсөвлөж оруулж ирдэг. Заавал энүүгээр гаргах албагүй. Бид нар энэ дээд хэмжээгээр төсөвлөж орж ирэхгүй бол яг шаардлагатай тохиолдолд өр нэгдүүлэх тохиолдолд төсвийн тухай хуулиар Их Хурлаас зөвшөөрөл аваагүй бол бид нар энэ хэмжээг нэмэгдүүлж чадахгүй гэсэн үг. Тэгэхээр энэ баталгааны орон зайгаа бид нар авч орж байж баталгааны хүсэлт ирсний дараа Их Хурлаар орж энийгээ шийдүүлнэ. Хэрвээ баталгааны орон зай авч орохгүй бол дараа нь хүсэлт ирсэн ч гэсэн энийг бид нар хангах ямар ч боломжгүй гэсэн үг. Засгийн газрын энэ дотоод бондын асуудал мөн яг адилхан. Бид нар дандаа дээд хэмжээ гэж авч байгаа. Дахин санхүүжүүлэх хэмжээг ч гэсэн дандаа хүртэл гэж авч байгаа. Энд хүрэх бол албагүй. Тэгэхдээ Их Хурлаас зөвшөөрөл авахдаа дандаа дээд хэмжээгээр авдаг. Өнгөрсөн жилүүд ч гэсэн бид нар гадаад зээлийг дахин санхүүжүүлэх хэмжээг дандаа тэрбум хүртэлх доллар гэж Их Хурлаас зөвшөөрлөө авч байсан. Тэгэхдээ бодит байдал дээр зарим нь жилүүд 500 сая хүртэл дахин санхүүжүүлээд л тэгээд л болж байсан.

Ч.Ундрам: Хэрлэн гишүүн асуулт асууя.

Б.Хэрлэн: Тэгэхээр би 2 чиглэлээр асуулт асууя.

Нэгдүгээрх нь цалин хөлсний реформтой холбогдуулаад. Тэгэхээр Монгол Улсын төрийн алба нэгдсэн удирдлагатай. Гэтэл өнөөдөр салбар бүрийн цалин хөлс харилцан адилгүй болчихсон. Тус тусын зохицуулалтаар явчихсан ийм байгаад байгаа. Тэгэхээр энийг жигдлэх цэгцлэх тухай дээр өнөөдрийн цалин хөлсний бодлого нэлээн чиглэж байгаа байх гэж бодож байна. Миний харж байгаагаар цалин хөлсний тогтолцоонд өнөөдөр 2, 3 асуудал үүсчээд байгаагийн нэг нь болохоор цалингийн бүтцийн асуудал байгаа. Үндсэн цалин, хувьсах цалингийн харьцааны асуудал. Зарим салбарт хувьсах цалин нь үндсэн цалингаасаа 2, 3 дахин их болчихсон байх жишээтэй. Заримд нь болоод ирэхээр нэг 70, 30-ын харьцаатай болчихсон байх жишээтэй. Харилцан адилгүй болчихсон байгаа.

Тэгэхээр энэ бүтцийг оновчтой зөв зохистой болгох тухай дээр 70, 30-ийн үндсэн цалин 70 хувь нь хувьсах цалин 30 хувь болгох тухай дээр яг ямар ахиц гаргаж байна гэж бодлогын түвшинд.

Хоёрдугаарх нь манай цалин дотор дандаа нөгөө төрийн захиргааны анхан шатын байгууллагын цалин хамгийн бага, төрийн захиргааны төв байгууллагуудын цалин маш өндөр тогтоогдсон учраас анхан шатад ажиллах хүн олдохгүй. Болж өгвөл аймаг руу, нийслэл рүү, тэгээд төрийн захиргааны төв байгууллага руу очоод ажлаа солих юмсан гэсэн ийм тэмүүлэлтэй болчихоод байгаа. Тэгэхээр яг төрийн үйлчилгээгээ анхан шатад хүргэж байгаа төрийн албан хаагчдын энэ анхан шатын байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг нэмэх тухай дээр ямар чигтэй байна вэ гэж.

Гурав дахь нь манай цалин чинь одоо ер нь бол ажлын үр ашиг, үр дүн, бүтээмж гэдэгтэй нэг их холбогдохгүй болчихоод байна л даа. Тэгэхээр энэ тухай дээр ямар бодлогын өөрчлөлтийг хийж байна вэ гэж би ТАЗ-өөс асууя.

Яагаад гэвэл түрүүчийн жил хэлж байсан л даа. Ер нь төрийн албан хаагчдын тогтвор суурьшил ялангуяа залуу боловсон хүчин тэнд тогтохгүй байна гэж хэлж байсан. Энэ тухайд 1 дүгээрт нь асууя.

Хоёрдугаарт нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой асууя. Яагаад гэвэл энэ хуулиар Эрдэнэс Тавантолгойн хувьцааг хоёрдогч зах зээл дээр шууд борлуулж эхэлнэ. Ингээд энэ Төсвийн тухай, Төсвийн тодотголын тухай хууль батлагдмагц энэ хууль хүчин төгөлдөр болохоороор ингэж орж ирж байгаа. Тэгэхээр өнөөдөр Эрдэнэс Тавантолгойн 1072 хувьцааг Монгол Улсын 2500 иргэн эзэмшиж байгаа.

Тэгэхээр энэ хоёрдогч зах зээлд энэ үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.9-д анхдагч зах зээлд борлуулахгүйгээр санал болгохгүйгээр шууд 2 дахь зах зээл дээр борлуулах эрхийг нь нээнэ гэсэн байгаад байгаа юм. Тэгэхээр яахаараа 2 дахь зах зээл дээр борлуулангуут хувьцааны үнэ ханш өснө гэсэн энэ ер нь баталгаатай юу? Яг энэ тухай дээр олон улсын мэргэжлийн байгууллагуудаас хийсэн нарийн судалгаа байна уу? Энэ судалгаануудыг би харж байж бид нар энэ дээр саналаа өгвөл их зүгээр байгаад байна л даа. Тэгэхээр ер нь бас төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулъя үйл ажиллагааг нь ил тод болгоё, иргэдийн хяналттай болгоё, хөрөнгийн зах зээлээ тэлье гэсэн энэ засгийн бодлогыг дэмжиж байгаа юм. Гэхдээ энэ бид нар зарим нэг юмыг тодруулах хэрэгтэй байна гэж би бодоод байгаа юм аа.

Тэгэхээр 2 дахь зах зээл дээр яг борлуулангуут яг нэгж хувьцааны үнэ ханш өсөх тухай ийм тодорхой судалгааны үр дүн тийм байна уу? Тийм байвал бид нарт харуулаачээ.

Хоёрдугаарт нь ингээд нээлттэй хувьцааг нээлттэйгээр хувьцааг борлуулаад эхлэхээр 1072 хувьцаагаа би нэг минутаа нэмээд авчих уу?

Ч.Ундрам: Хэрлэн гишүүнд нэмэлт минут өгье.

Б.Хэрлэн: Тэгэхээр энэ маань иргэд 1072 хувьцаагаа. Одоо бүгдээрээ ингээд 2 дахь зах зээл дээр борлуулах арилжих эрх нь худалдаж авах нь шууд ингээд нээгдээд явчих уу, нээлттэй болчих уу?

Энэ үед зах зээлийн янз янзын манипуляцууд хийгддэг. Тэрнээс иргэдийнхээ орлогыг хамгаалах, иргэдийнхээ нөгөө байгалийн баялгаасаа хүртэх энэ эрхийг нь хамгаалах тухай дээр СЗХ, Засгийн газар энэ дээр ямар үүрэг оролцоотой байх юм бол? Энэ дээр ямар бодлого баримтлах юм бол? Энэ тухай дээр нэг тодорхой хэлж өгөөч ээ. Энэ маш чухал шийдвэр. Энийг бид нар нэлээн бодож тунгааж байж энэ дээр шийдвэр гаргах ёстой байх л даа. Тэгэхээр энэ тал дээр тодорхой мэдээллүүдийг өгөх үү?

Ч.Ундрам: Цалин хөлсний реформ, цалингийн бүтэц. Мэндсайхан сайд 6 номерын микрофон дээр хариулъя.

3.Мэндсайхан: Хэрлэн гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр цалингийн асуудал ер нь бол өнгөрсөн жилийн жишээн дээрээс л харахад 2 салбарын цалинг бид нар нэмчихсэн. Ингээд цалингийн нэгдсэн бодлого

алдагдаад яваад байгаа л даа. Тэгээд бусад салбараас нь ингээд сугалаад шийдчихээр зэрэг нөгөө талдаа үлдэж байгаа салбарууд маань барьцах тэд нарын цалин хөлсийг зайлшгүй нэмэх л асуудал үүсэж байгаа. Боловсрол эрүүл мэндийн цалинг өнгөрсөн жил нэмчихсэн. Үүнтэй холбоотойгоор сая төрийн үйлчилгээний албан хаагч нарынхаа цалинг бид нар нэмэгдүүлээд төсвийн тодотгол дээрээ оруулж ирж байна. Ер нь зүгээр яах вэ цалин хөлсөн дээр Засгийн газар Цаашдаа энэ цалин хөлсийг зохицуулж байгаа 33, 34 орчим хууль байна. Эд нарыг нэгтгээд бид нар цалин хөлсний нэгдсэн бодлоготой явахгүй бол 1 дүгээрт болохгүй байна.

Ийм учраас Засгийн газар ойрын хугацаанд энэ хуулийн төслийг оруулж ирнэ Их Хуралд. Нөгөө талдаа бид нар энэ зэрэг дэв гээд үндсэн цалин дээр нэмэгдэх энэ асуудлуудыг ерөнхийд нь үндсэн цалинд нь оруулж тооцох, хувьсах зардал буюу одоо юу байгаа шүү дээ урамшууллуудыг. Энэний үр дүнгийн урамшууллыг бид нар бүтээмжээр цаашид нь бүтээмжийг үнэлэх энэ чиглэл рүү нь илүү нарийсгахгүй бол үндсэн цалин нь өөрөө бага. Ингээд нөгөө элдэв зэрэг дэвийн нэмэгдэл ингээд дээр нь урамшуулал гээд ингээд явахаар энэ 2-ын харьцаа бол алдагдаад байгаа юм.

Ер нь цаашдаа бид нар үндсэн цалин урамшууллын асуудал 70, 30-ийн харьцаатай явах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа.

Ч.Ундрам: Нэмээд Цэдэвсүрэн дарга нэг номерын микрофонд хариулъя.

Л.Цэдэвсүрэн: Хэрлэн гишүүний асуултад хариулъя.

Түрүүн товчхон мэдээлэл өгсөн. Цалин хөлсний хувьд яг Засгийн газартай нөгөө хамтарсан ажлын хэсэг ажиллаж байгаа учраас бид нар яг ер нь бараг нэгдсэн байр суурь дээр ирээд тохирчихсон явж байгаа. Манай байгууллагын хувьд бид нар ер нь төрийн албаны энэ цалин хөлсийг чиг үүрэг, ачаалал, бүтээмж, үр дүнд суурилсан цалинтай байх ёстой гэсэн ийм зарчмыг тавьж байгаа. Харилцан адилгүй байгаа сая Мэндсайхан сайдын хэлж байгаа 33 хууль өнөөдөр цалингийн хуулиуд явж байна. Таны асууж байгаагаар сумын ЗДТГ-ынхны цалин хөлсний асуудлыг хөндөж байх шиг байна. Хамгийн доод тал нь 1.1 сая хамгийн дээд тал нь 2.5 саяын цалин үндсэн цалин нь авч байна л даа тэгээд бүтцийн хувьд яг адилхан.

Ер нь үндсэн цалин нь ахиу байя. Нэмэгдлүүдийг харилцан өөр хувилбар руу оруулъя гэсэн ийм бодлого явж байгаа. Тэгэхээр үндсэн цалин 30 хувийн нэмэгдэл рүү орох ийм боломж байгаа.

Ч.Ундрам: Дараагийн асуултад нь хэн хариулах вэ? 7 номер Санжаадорж дарга хариулах уу эсвэл Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулах юм уу? 9 номер Санхүүгийн зохицуулах хороо юу.

Б.Дөлгөөн: Сайн байцгаана уу? Хэрлэн гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны газрын дарга Дөлгөөн.

Эрдэнэс Тавантолгой компанийн хувьд бол энэ удаагийн үнэт цаасны зах зээлийн тухай хуульд оруулж байгаа өөрчлөлтийн хувьд бол энэ олон улсад дайркт листинг буюу энэ нөгөө шууд бүртгэх ийм зохицуулалт байдаг. Үүнийг бол ялангуяа хувьцаа эзэмшлийн төвлөрөл нь олон нийтэд олон хувьцаа эзэмшигчтэй байх тохиолдолд олон улсад бол биржүүд дээр энийг шууд бүртгэх боломжтой

байдаг. Тэгэхээр энэ аргачлалын дагуу бол Эрдэнэс Тавантолгой компанийн одоо байгаа хувьцаа эзэмшил нийтэд эзэмшиж байгаа хувь бол 26 хувь гаруй байгаа учраас энийг бол шууд бүртгэх ийм бүрэн боломжтой байна гэсэн ийм тооцоо судалгаа гарсан. Ер нь олон улсад биржүүд дээр ер нь прий плот буюу энэ олон нийтийн эзэмшиж байгаа хувь хэмжээ 20 болон 25-аас энэнээс дээшээ байхыг шаарддаг.

Эрдэнэс Тавантолгой компанийн тухайд бол Монгол Улсын иргэд болон ААН-ийн эзэмшиж байгаа хувь нь бол 26 хувь гаруй байгаа. Тэгэхээр энэ бол олон улсын шаардлагыг хангана гэж үзээд энэ удаагийн хуулиар оруулсан байгаа.

Ч.Ундрам: Хэрлэн гишүүн тодруулъя.

Б.Хэрлэн: Би уг нь их 2 тодорхой асуулт асуусан шүү дээ.

Нэгдүгээрх нь яг 2 дахь зах зээл дээр 1072-оо бо юу борлуулахад нэрлэсэн үнээсээ энэ нь үнэ нь унахгүй хувьцааны ханш өснө гэсэн яг ийм бүр баталгаа байгаа юу? Олон улсын мэргэжлийн байгууллагуудаар хийсэн ийм судалгааны үр дүн байна уу? Тэрийгээ нэг танилцуулаач гэж.

Хоёр дахь нь зах зээлийн янз янзын манипуляц иргэдийн гар дээр байгаа 26.44 хувьцаа чинь хэрвээ янз янзын манипуляцийн үр дүнд хэсэг цөөнхийн гар дээр төвлөрчих вий гэж би болгоомжлоод байгаа байхгүй юу. Тэгэхээр яг ийм үед засаг дээр нь Санхүүгийн зохицуулах хорооноос нэг тодорхой эрсдэлээс нь хамгаалсан тодорхой бодлого хамгаалах хянах ийм арга механизмууд та нар юу төлөвлөж байна вэ гээд би ийм 2 тодорхой юм асуугаад байгаа юм.

Ч.Ундрам: 9 номер СЗХ хариулъя. Тэгэхдээ Хэрлэн гишүүнээ энэ нөгөө манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бид нар асуух ёстой юм байна Дэгийн хуулиар ер нь бол. Тийм учраас Эдийн засгийн байнгын хороон дээр асуух ёстой юм байна лээ шүү. 9 номер хариулт өгье.

Б.Дөлгөөн: Эрдэнэс Тавантолгойн хувьцаа бол анх гаргахдаа нэрлэсэн үнэ, буюу 933 төгрөгөөр үнэлж тухайн үед гаргаж байсан. Ер нь олон улс болон Монгол Улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу хэрвээ нээлттэй ХК гарах гэж байгаа бол зайлшгүй компанийн бизнес үнэлгээ болон бусад яг энэ ялангуяа Эрдэнэс Тавантолгой өөрөө уул уурхайн компани учраас яг энэ уул уурхайн олон улсын яг үнэлгээний стандартад нийцсэн аргачлалын дагуу үнэлгээ зайлшгүй гаргах ёстой байгаа.

Тэгэхээр энэ үнэлгээний аргачлал гарсны дараа бол ер нь нэгж хувьцааны үнэ ойролцоогоор зах зээл дээр эд орчим болно оо гэдэг тийм тооцооллууд гарах ёстой юм. Одоо бол энэ судалгаа бүрэн хийж дууссан гэсэн мэдээлэл байхгүй байна.

Хоёрдугаарт нь бол 933 төгрөгөөр гарч байх үед бол энэ тус компани бол дөнгөж эхлэлийн төслийн эхний шатандаа явж байсан одоо бол тус компани нь бол нэлээн ашигт ажиллагаандаа орчихсон ер нь ноогдол ашгийн өгөөж бараг 20-30 хувьтай байгаа учраас энэ тодорхой үнэлгээ өснө гэж харж байгаа юм.

Хоёрдогч зах зээл дээр бол манипляц болон бусад.

Ч.Ундрам: 9 номер гүйцээж хариулъя. Хоёрдогч зах зээл дээр бол яг энэ хувьцаа эзэмшлийг ялангуяа үнэ ханшид зохиомлоор нөлөөлөх энэ агуулгын хүрээнд бол энэ холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд ч хүртэл Эрүүгийн хуульд заасан ийм гэмт хэргийн шинжтэй буюу манипуляц буюу энэ зах зээлийг урвуулан ашиглах ийм гэмт хэрэг гэж хүртэл үздэг. Энэ ч агуулгаараа бол Хөрөнгийн биржийн арилжаан дээр бол хяналтын үйл ажиллагааг Санхүүгийн зохицуулах хорооноос хийдэг биржийн өөрийнх нь үйлдэл хүртэл хийгдэж байгаа сурваленс гэж нэрлэгддэг. Тэгээд энэний энэ аргачлалын дагуу хэрвээ зах зээлд ямар нэгэн сэжигтэй ийм асуудал илрэх юм бол тухай бүр нь бол Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэж энэ талаар хяналт хяналт шалгалт хийгдэж байгаа. Нөгөө талдаа мэдээж иргэд хувьцаагаа зараад нэг этгээд илүү их хэмжээний төвлөрөх эрсдэлийн асуудал байгаа.

Ялангуяа нийт иргэдэд хуваарилсан. Энэ Төрийн өмчит компани өөрөө энэ нээлттэй ХК болж байгаатай холбогдуулаад нэг этгээд аливаа этгээд болон бусад этгээдийн хамт эзэмших дээд хэмжээг 5 хувиар хязгаарласан нэг зохицуулалт бий.

Ч.Ундрам: Хэрлэн гишүүн тодруулж асууя.

Б.Хэрлэн: Яг тэгэхээр би асуултынхаа хариуг боломжтой бол бичгээр авчихъя танайхаас. Саяын 2 асуултад бүүр тодорхойгоор надад хариулт өгчхөөрэй. Тэгэхээр энэ төсвийн тодотголын хууль батлагдсанаар энэ хууль хүчин төгөлдөр үйлчлэх гэж байгаа болохоор энэ бол Монгол Улсын тэр 2 сая 500 иргэний хувьд бүгдээрэнд нь хамаатай асуудал учраас би нэг асууя гэж бодсон.

Хоёрдугаарт нь Төрийн албаны зөвлөл болоод Санхүүгийн зохицуулах хороо Улсын Их Хурлын харьяа байгууллага учраас та бүхний ажил үүрэгтэй холбоотой асуултуудыг асуугаад байгаа юм шүү. Баярлалаа.

Ч.Ундрам: Гол нь Хэрлэн гишүүний санаа зовоод байгаа юм нь нөгөө цэнхэр ягаан тасалбар шиг болчих вий. Нэг нь тэгээд нөгөө бусад иргэд нь мэдлэггүйгээс болоод тэгээд зарчих вий гэдэг зүйл асуугаад байна шүү дээ. Тэгэхээр бас нөгөө бусад хүмүүсээ мэдлэгтэй болгох, сургах тийм юмыг маш сайн анхаарах ёстой юм болов уу гэж бодож байна. Алтангэрэл гишүүн асуулт асууя.

О.Алтангэрэл: Гишүүд өнөөдөр энэ цалин хөлсний тогтолцоо яриад байгаа нь ерөөсөө энэ цалин хөлсний чинь тогтолцоо ингээд алдагдахаар энэ хөдөлмөрийг үнэлэх шударга ёсны тогтолцоо нь ингээд хамт алдагдчихдаг юм байна. Хөдөлмөрийг үнэлэх шударга ёсны тогтолцоо алдагдчихдаг юм байна. Өнөөдөр сая яах вэ хариултад гарч байна тэр суманд жишээлбэл ЗДТГ 1 сая 200-аас 2 сая 500 гэж байх шиг байна. Үгүй тэр чинь ЗДТГ-ын дарга нь л нэг чүү чамай 2 сая гаран авч байгаа шүү дээ. Тэгээд тэр олон ажилчид төрийн албыг өдөр шөнөгүй нойр хоолгүй хийж байгаа залуучууд шударга бусаар цалин авч байна гэдэгтээ өөрсдөө итгэлтэй байгаа.

Өнөөдөр ковид гарсан өнгөрсөн жилүүдэд нөгөө нэг хэдэн сумын Тамгын газрын албан хаагчид машиндаа өнжиж хоноод л хэн сум руу оров гарав гээд л ингээд л жижүүрлээд байж байдаг. Ой болно оо баяр наадам болно. Тэнд хоол цай зөөгөөд л айраг бариад л гүйж байдаг. Хамаг хар ажлыг хийнэ. Тэгээд дандаа энэ нэг цалин хөлсний нэмэгдэл энэ юмнаас үлдэж хоцроод байна аа. Энэ яагаад байна

гэвэл бид нар нэмэгдсэн хэсгийг нь буруутгаж байгаа юм биш. Шударга бус байна. Энэ тогтолцоо чинь өөрөө шударга бус байдаг юм байна. Ингээд энэ тогтолцоо алдагдчихаар төрийн албаны нөгөө ранк, зарчим бүгд алдагдаад явчхаж байгаа байхгүй юу.

Тэгээд л ёстой яг хөрөөний ир шиг. Өө энэ хэсгийг нэмье, энийг нэмчихсэн юм чинь энийг нэмье гээд ингээд системгүй яваад байгаа байдлаас чинь болоод Монгол төрд зүтгэж байгаа нэн ялангуяа энэ төрийн албаны энэ дунд, доод шатанд ажиллаж байгаа энэ хэсэг чинь хэзээ нэг энэ цалин нэмэгдэх нь вэ, хэзээ аятайхан болох нь вэ хэзээ бид нар дээр энэ шударга ёс нь ирэх нь вэ гээд хүлээгээд байгаа юм аа. Тэгээд Монгол Улсын Ерөнхий сайд Их Хурлын дарга байхдаа орон нутгуудаар яваад тэгээд ер нь энэ төрийн албаны шинэчлэлийг хийнэ гээд ингээд нэлээн сайхан хөтөлбөрөө танилцуулаад тэр үед нь орон нутгийнхан алга ташиж хүлээж авсан өөрчлөгдөх юм байна гээд. Тэр шинэчлэл ер нь явж байна уу үгүй юу? Ингээд зогсчихсон юм уу? Тэгээд би яг нэр цохоод энэ байгууллагуудаас нь асууя.

Сангийн яамнаас сая сайд хариулж байх шиг байна. Энэ шинэчлэлийг төрийн албаны цалингийн сүлжээ, зэрэглэл, үр дүнг үнэлэх энэ системээ та бүхэн маань ТАЗ-тэйгөө бусад байгууллагатайгаа хамтраад нэг цогц ярьж байна уу? Одоо сонсохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр нэг хуулийн төсөл байгаа. Ер нь засаг дээр нэг хуулийн төсөл байгаа гэж эд нар чинь нэг үү, бодлого чинь нэг үү? Энийг хийхдээ юу юуг харгалзах гэж байна. Энэ чинь яг хэзээ хэзээ хуулийн төсөл болж, хэзээ биежиж энэ төрийн албан хаагчдын энэ ялгаа зэрэглэл, шударга ёсыг тогтоож ер нь орж ирэх вэ гэдэг 1 дүгээр асуулт.

Хоёрдахь асуулт. Би Магнайсүрэн даргаас асууя. Ер нь байна шүү дээ энэ шаардлага хангахгүй хүмүүс томилогдчихсон төрийн өндөр албан тушаалд томилогдчихоод өндөр цалин аваад байгаа явдлууд байгаа шүү дээ. Таны орлогч сүүлд томилогдсон орлогч чинь төрийн албаны нөхцөл шаардлагыг яг хангаж томилогдсон уу? Та яг ингээд Их Хурал, Байнгын хороон дээр үнэн зөв хэлэх ёстой хэлээч. Яаж томилогдсон түр орлож байгаа юм уу, одоо томилж байгаа юм уу? Наад орлогч чинь.

Нийслэлээс асууя аа. Үгүй нийслэл гэснээс хуучин бол ингээд Нийслэлийн засаг дарга нь сууж байдаг байсан. Нөгөө Нямдорж сайдын нэг эзнээ үзчих юмсан гэдэг шиг НЗД-ынхаа барааг нэг харчих юм сан хөөе. Энэ ТББХ, Улсын Их Хурлын үйл ажиллагааг хүндэтгээд ирдэггүй юм уу? Энэ Байнгын хороонуудад ерөөсөө харагдахгүй юм. Ядаж ажил хариуцах хүн нь ирж болдоггүй юм уу? Тэгээд нөгөө Туулын хурдны зам юу болсон бэ? Тэрний мөнгө санхүү юм юу болсон. Мөнгө төгрөгийг нь урьдчилаад шилжүүлчихсэн гэсэн. Одоо юу болсон, яасан? Төсөв дээр чинь яаж төлөвлөж ингэж явж байна гээд нэг минут нэмээд авчихъя дарга аа.

Ч.Ундрам: Алтангэрэл гишүүн нэг минут нэмье.

О.Алтангэрэл: Нийслэлээс ийм асуулт.

Сонгуулийн ерөнхий хорооноос асууя. Ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгууль, 2028 оны Улсын Их Хурлын сонгуулийн бэлтгэлийг хангах зорилгоор сонгуулийн энэ санал тоолох машинтай холбоотой санхүүжилттэй холбоотой нэлээн олон хүндрэл бэрхшээл ярьж байсан Сонгуулийн ерөнхий хороо. Яг энэ манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд. Энэ асуудал чинь юу болж

байгаа вэ? Худалдан авалт төсөв мөнгө нь яаж байгаа вэ? Хариуцлагатай сонгууль зохион байгуулахад бэлэн үү? Тэр сонгуульд оролцох гэж байгаа хүмүүс нь бэлэн байх шиг байна. Зохион байгуулах гэж байгаа та хэд бэлэн үү?

Төрийн албаны зөвлөлөөс асууя. Энэ түр орлон гүйцэтгэгч гэж тийм олон хүмүүс байгаа юм байна. Энэ түр орлон гүйцэтгэгч нар дунд энэ цалин хөлс өндөртэй төрийн өндөр албан тушаал хашиж байгаа ер нь хэчнээн хүн байгаа вэ.

Ч.Ундрам: Эхний асуултад Мэндсайхан сайд. 6 номер дээр хариулъя.

3.Мэндсайхан: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр цалин хөлс дээр тантай санал нэг байна аа. Ер нь одоо өнгөрсөн жилийн энэ цалингийн ингээд сугалаа шийдчихэж байгаа асуудал. Бид нар ерөнхийдөө энэ цалин хөлсний араас хоцорч хөөж явна шүү дээ. Одоо тодотголоор бид нар эрүүл мэндийн салбарыг нэг 20 хувь нэмээд, төрийн үйлчилгээг нэмээд оны эцэст нэг жигдлээд авъя. Цаана нь үлдэж байгаа нөгөө төрийн захиргаа, төрийн тусгайгийнхнийгээ ирэх оны 4 сарын 1-нээс нэмэгдүүлээд явъя. Ингээд нэг түвшинд аваад ирье гэж байгаа юм. Гэхдээ бид нар таны асууж байгаа тэр хуулийн төслийг яаралтай яаж бид нар цалин хөлсний системээ нэгтгэж авахгүй бол ахиад нэгийг нь өсгөнө. Ингээд Засгийн газар инфляцтай уялдаад нэг дор бүгдийг нь жигдэлж чадахгүй учраас төсөв мөнгөнийхөө хүрэлцээнээс хамаараад ингээд хөөгөөд яваад байгаа юм.

Тэгэхээр таны асууж байгаа тэр хуулийн төсөл бол бид нар нэг хуулийн төсөл дээр л ярьж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа Сангийн яам ярьсан. Тус хуулийн төслөө бол түр тааз руу хүргүүлчихсэн байгаа. Ингээд ойрын хугацаанд оруулж ирж цэгцэлж авахгүй бол бид нар цаашдаа ингээд л аль нэг салбарыг нь ямар нэгэн байдлаар өдөөгөөд нэмчихдэг, тэгээд Засгийн газар энэнийхээ араас чирэгдээд явдаг ийм л юм руу орох гээд байна. Тэгэхээр энэ дээр бол энэ намрын чуулганаар оруулж ирэх гэж байгаа хуулийн төсөл бол Засгийн газар, Хөдөлмөр хамгааллын яам, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл дээр явж байгаа хууль бол нэг үзэл баримтлалтай, нэг төсөл явж байна гэж ойлгож болно.

Ч.Ундрам: Монгол Улсын ерөнхий аудитор Магнайсүрэн 5 номерын микрофон дээр хариулт өгье.

С.Манайсүрэн: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

С.Магнайсүрэн: Үндэсний аудитын газар Магнайсүрэн. Маш тодорхой товч хариулахад нэг орлогчийн маань асуудал байгаа. Төрийн албаны зөвлөлийн шалгалт аудит манайд орж ирээд гарсан. Энэ дээр тогтоол гарсан. Энэ хүнийхээ асуудлыг шийд гэдэг ийм тогтоол гарсан. Би сонсох ажиллагаа хийгээд ингээд бэлтгэсэн. Тэгээд одоо амралтаа аваад орж ирэнгүүт нь ингээд асуудал шийдэхээр сонсох ажиллагаа хийгдээд тохирчихсон ингээд байж байгаа. Ер нь асуудлыг хуулийн дагуу болгоно оо гэдэгт, удахгүй.

Ч.Ундрам: Энэ нийслэлээс ирсэн Эрдэнэбадрах дарга 9 номер руу суугаарай. Тэгээд яагаад танай Засаг дарга ирсэнгүй вэ гээд асуултуудад нь хариулъя. 9 номер.

Эрдэнэбадрах: НЗДТГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Эрдэнэбадрах байна. Өнөөдөр НИТХ-ын АН-ын бүлэг хуралдаж байгаа. Тэгээд тэрэн дээр Засаг дарга болон орлогч дарга оролцож байгаа учраас миний бие ирсэн байгаа.

Туулын хурдны замын асуудал бол 4 сарын 22-оос хойш ажил нь зогссон байгаа. Тэгэхээр одоогийн байдлаар ажлын хэсэг гарчихсан ажиллаж байна. Ажлын хэсгийн дүгнэлт гараад эцэслэсний дараагаар энэ Туулын хурдны зам хэрхэн шийдвэрлэх талаар бол тодорхой шийдвэр гарна. Тэгэхээр одоогийн байдлаар явсан юм байхгүй зогссон байдалтай байгаа.

Ч.Ундрам: Сонгуулийн ерөнхий хорооны Мягмар дарга 9 номер дээр хариулъя.

Н.Мягмар: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

СЕХ хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын ээлжит сонгууль ард нийтийн санал асуулгыг зохион байгуулах үүргийнхээ хүрээнд ажиллаж байгаа. Энэ ээлжит сонгуульд Сонгуулийн автоматжуулсан системийн хуулийн дагуу бид бүхний ярьдгаар хар машин буюу сонгуулийн санал тоолох дүнгийн автомат машиныг 2012 оноос хойш ашиглаж ирсэн. Анх 2500 ширхгийг худалдаж авч 2012 оноос хойш нийтдээ 11 удаагийн сонгуульд ашигласан байгаа юм. Энэ сонгуулийн машины шинэчлэх шаардлагыг бол жил болгоны төсөвт саналаа хүргүүлж өнгөрсөн онд нийтдээ 3 мянган машин авах ёстой гэдэг ажлын хэсгийн санал, дүгнэлт гарсны дагуу бол 41.7 тэрбумын саналыг хүргүүлж 2026 оны төсөвт бол 30 хувь буюу ойролцоогоор одоо.

Ч.Ундрам: Гүйцээж хариулъя. Ирэх жилийн төсөвт үлдсэн нь суусан юм уу үгүй юу та тодорхой хариулаарай.

Н.Мягмар: 900 орчим машин худалдан авах зардлын санхүүжилт бол батлагдсан. Энэ худалдан авах ажиллагааг бол зохион байгуулаад бид 7 сарын 28-аас 30-ны хооронд бол энэ батлагдсан төсвийн хүрээнд авах энэ 900 гаруй машиныг бол хүлээж аваад байна. Одоо техникийн шалгалт баталгаажуулалтыг хийхээр холбогдох үйлдвэрлэгч байгууллагын төлөөлөгчтэй бэлтгэл ажлаа хангаад ажиллаж байгаа. Үлдэгдэл төлбөр болох 3 мянга хүртэлх, 2 мянган төхөөрөмжийн төсөв бол ирэх оны төсөвт суучихсан явж байгаа. Ирэх оны төсвийн төсөлд ороод ирчихсэн байгаа учраас Улсын Их Хурлын гишүүд маань батлаад өгчихвөл сонгууль зохион байгуулахаас өмнө эхний улиралдаа багтаагаад үлдэгдлээ аваад сонгуулийн бэлтгэл ажлаа хангачихна гэсэн ийм тооцоотой ажиллаж байна.

Ч.Ундрам: Нэг номерын микрофон Цэдэвсүрэн дарга.

Л.Цэдэвсүрэн: Алтангэрэл гишүүний асуултад хариулъя.

Түрүүний тэр хууль тогтоомж зөрчөөд түр орлон гүйцэтгэгчийг тодорхой хугацаанд хийж байгаа төрийн албан хаагчдын тоон мэдээллийг өгсөн. Ерөнхийдөө бол энэний хойноос хяналт шалгалт давхар хийгдээд явж байна. Заримыг нь хууль ёсны болгож өнөөдрийг хүртэл 2, 3 сонгон шалгаруулалтуудыг зохион байгууллаа. Таны төрийн өндөр гэдгээсээ илүүтэй нөгөө удирдах албан тушаалтнуудын судалгаа байгаа. Яамны төрийн нарийн агентлагийн дарга, ЗДТГ. Яг бид нарын 8

сарын 31-ийг тасалбар болгож авсан судалгаагаар 34 хүний одоо хууль тогтоомж зөрчсөн түр орлон ажиллаж байна аа. Энийг өнөөдрийн сонгон шалгаруулалтаар 2 нь ямар ч байсан засагдаад ингээд явж байх жишээний. Тэгэхээр энэ бол тасралтгүй ингээд хийгдээд явна.

Бид нар мөн энэ байгууллагууд руугаа хандаж энэ сонгон шалгаруулалтуудыг маш яаралтай зарлуулж энэ ажлыг хийж байгаа.

Ч.Ундрам: Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Энэ 3 сан маань дэгийн хуулиараа хэлэлцэх асуудалд орж байгаа нь зөв үү, буруу юу? Тэр дэг дээрээ бид нар ТББХ оруулах ёстой юу үгүй юу гэдгийг нэг анхаараад хариулах нь зүйтэй байх.

Тодотголын үндэслэлээ бид нар төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх гэсэн. Тэгээд нийт зарлага 998-аар өсөөд алдагдал болохоор 2 байж байгаа. Орон нутгийн хуваарилалт өөрчлөгдсөн багцтайгаа тохирч байгаа юм уу үгүй юм уу гэдгийг асуумаар байна.

Гуравт нь 998-ын зарцуулах эрхийгээ аймаг нийслэл тус бүрээр нь тийм задалсан жагсаалтыг хийх үү? Энэ задалсан жагсаалт төсвийн тодотголыг батлахад орох уу хэдэн аймагт ямар хэмжээний үлдэгдэл байна вэ гэдэг энэ задаргааг гаргаж ирүүлэх хэрэгтэй байна. Чуулганаар хэлэлцэхээс өмнө. Дундговь, Ховдод одоо жишээ нь 38 дахин өссөн энэ тооцооны үндэслэлүүд нь юу юм бэ гээд. Энэ тооцооны үндэслэлүүдээ гаргасан зүйлүүд байна. Дундговийн 06 маань 21 тэрбум болсон. Ховдын 09 маань 13.3 болсон гэх мэт. Өмнөговийн тэр 155.3 гээд байж байгаа. Энэ чинь уул уурхайн бүтээгдэхүүний бууралт юм уу, бодлогын шийдвэр болгож Өмнөговь аймгийн тэр орлогыг аймагт нь үлдээж шийдэж байгаагаа төсөв дээр ингэж оруулж ирж байна уу? Энэнийхээ танилцуулга энэнийхээ 155-аа юугаараа нөхөж байгаа юм? Тэгээд 1 ноогдол ашгийг үлдээж байгаа бол дараа жил 2027 онд энэ ноогдол ашиг дахин давтагдаж чадах юм уу үгүй юм уу гэдгийг асуумаар байгаа юм.

Орон нутгийн хөгжлийн сангийг 122.7 тэрбумаар өссөн аргачлалыг яаж тооцож байгаа юм бэ? Рояалти тэр зэсийн үнэ нүүрсний үнээсээ бодож байгаа юм уу? Яаж тооцож байгаа юм? Энэ төсвийн тэр 3 дугаар зүйлд 11 дүгээр зүйлийн 367, 653.5 гэсэн тоо маань техникийн алдаа юу өөр алдаа байна уу? Нэг бол зүгээр би алдаа байна гэж буруу хараад байна уу? Энийгээ нэг анхаарахгүй бол нөгөө ингээд батлагдаад явчихвал энэ чинь хэрэгжихгүй заалт болоод хувирчихна аа. Үүн дээр хариулт өгөх хэрэгтэй. ХЗДХЯ чинь энийгээ хянаж байгаа шүү дээ.

Тэгэхээр ХЗДХЯ энэн дээр хяналт нь зөв гүйцэд явж чадсан юм уу үгүй юм уу. Төсөв өөрөө том учраас бүх зүйлийг нь харж амжаагүй байж магадгүй. Үүн дээр тодорхой асуулт асууя. Үндсэн цалин 22.1 хувь нь давсан нь орон тоо юм уу, төлөвлөлтийн алдаа юу, зэрэглэлийн шилжилт болж байгаа юм уу гэдэг сүлжээнийхээ шинэчлэлээр энэ нэмэгдлээсээ үндсэн цалинд шилжсэн гээд та бүхэн тайлбарлах байх л даа. Тэгээд энэ чинь бүтэц шилжсэн ч гэсэн жилийн цалингийнхаа төсвөөр тогтоосон цалингийнхаа 85.1 хувийг зарлагадаад цалин тооцоондоо тавьчихсан байдаг. Үлдсэн хагас жил буюу үлдэж байгаа хугацаанд цалингийн өр төлбөр үүснэ. Энэ жилийнхээ тодотгол жилийн дүнг хэд болгож засаж байгаа юм бэ? Ялгаатай нэмэгдэл гээд гишүүд асуугаад байгаа. Салбар бүрээр

20.35, 50 хувийн нэмэгдэл 20, 35, 50 гээд ингээд янз бүрийн хувьтай нэмэгдлүүд яаж байна. Тэгээд Төрийн албаны зөвлөл энэ хуулийнхаа нэгдсэн тогтолцоотой хэрхэн нийцэж байгаа тал дээр нь дүгнэлт гаргаж өгсөн үү. Хууль салбарынхаа нэмэгдлийг зөвшөөрдөг. Тэгэхлээр чинь Төрийн албаны зөвлөл маань зөвшилцсөн юм уу, энэ төрийн албаны зөв зөвлөл ТББХ-нд тайлагнасан асуудал байна уу үгүй юу гэдгийг асууж байна.

Нэмэгдэл 53.2 хувь чинь дутуу байж байгаа гээд ингээд дутуу санхүүжсэн хуулийн нэмэгдлийг олгоогүй гэсэн үг үү? Эсвэл?

Ч.Ундрам: Батбаатар гишүүнд нэмж минут өгье.

Б.Батбаатар: Тэгээд ээлжит бус чуулганыг заавал 9 сарын 15-аас өмнө ингэж хуралдуулах нь боломжгүй байсан шалтгаанаа бас нэг дахиад нэг хэлээд бодвол Хэрэг эрхлэхийн дарга хэлэх үү, Сангийн сайд хэлэх үү? Хэлэх хэрэгтэй байх. Үүн дээр асууж байна. Тэр ТӨБЗГ гэж байгаа. 81.6 байсан байхаа. Тэр чинь 1 их наяд 147 тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрүүлэх төсөвт орлого оруулахаар ингээд өөрчилж байгаа.

Тэгэхээр энэ агентлагийн ТӨБЗГ-ын агентлагийн энэ чиг үүрэг дотор ямар нэг өөрчлөлт орох уу? Энэ чинь уг нь бол ийм төвлөрүүлэгч Засгийн газрынхаа тогтоолоор ийм төрийн өмчийн компанийн ноогдол ашгийг төвлөрүүлэгч ийм л газар. Их Хурлын төсөв 1.2 тэрбумаар буурч байгаа.

Ч.Ундрам: Сангийн сайд 6 номер дээр хариулъя.

3.Мэндсайхан: Батбаатар гишүүний асуултад хариулъя.

Төсвийн тодотгол дээр төсөв хоорондын ерөнхийлөн захирагч нарын хооронд зохицуулалт хийх шаардлага үүссэн. Тэгэхдээ энэ дээр тэр таны асууж байгаа 998-аар нэмэгдсэн байна гэж байгаа гэдэг бол төсвийн тодотголтой зэрэгцүүлээд бид нар төсвийн тогтвортой байдал болон төсвийн хүрээнд өөрчлөлт орж байгаа. Энүүгээр төсөв дээр төсвийн тэнцэл дээр 1 их наядын зардлын орон зай гарч ирж байгаа юм. Энийг орон нутагт өгье гэж байгаа. Та тэгээд нөгөө Төсвийн тодотголын хуулийн төслийн хавсралт 12 дээр байгаа аймаг нийслэлээр нь ирсэн хүсэлтийг нь гаргачихсан байгаа.

Нийслэлээс гэхэд 603.9 тэрбум, дараагийн гол том аймаг Өмнөговь аймаг байгаа. Тэгээд бусад аймгууд нь гарчихсан энүүгээр нь энэ төсвийн тодотгол батлагдсаны дараа тухайн орон нутгийн иргэдийн хурал, төсөл хөтөлбөрүүдээ шийдээд явна. Зүгээр ер нь нийслэл дээр үүсчихсэн байгаа санхүүжилт нь байгаа хэдий ч төсвийн зардлын орон зайгаас хамаараад гаргаж чадахгүй хуримтлагдчихсан 2.8 их наядын хөрөнгө оруулалтын асуудал байгаа. Энэний гол асуудал бол Сэлбэ дэд төвийн, тэгээд нийслэл бол энэ гаргаж байгаа орон зайгийн бараг 60 орчим хувийг нь нийслэл дээр гараад явна гэсэн үг. Энэ зардал нэмэгдсээр байгаад төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр буюу улсын төсөв дээр нэмж зардал гарч байгаа асуудал биш.

Ч.Ундрам: Өөр нэмж хариулах хүн байна уу? Тэр Улсын Их Хурлын төсөв буурчихсан байна. Тэр ямар учиртай юм гэнэ. Улсын Их Хурлын Тамгын газрын

Санхүү хангамжийн хэлтсийн дарга Лхагвасүрэн байна уу? 9 номер дээр суугаад хариулаарай.

Б.Лхагвасүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын төсөв нийт дүнгээрээ 1.2 тэрбум төгрөгөөр буурсан. Үүнээ Улсын Их Хурлын Тамгын газраас 392, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 21.9, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс 741.9 сая төгрөгөөр төсөв тус тус буурсан байгаа.

Улсын Их Хурлын гишүүдийн өөрийн үндсэн төсөв зардлаас буураагүй хэвийн байгаа.

Ч.Ундрам: Тэгэхээр жишээлбэл парламентын судалгааны хүрээлэн судалгаа хийхгүй болж байна уу, яг юуных нь төсвөөс хасчхав, цалин юм уу урсгал зардал юм уу, тоног төхөөрөмж юм уу. 9 номер гүйцээж хариулъя.

Б.Лхагвасүрэн: Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгийнх нь болохоор зэрэг гэрээт ажлын зардлууд ерөнхийдөө ихэвчлэн энэ болохоор сургалт судалгааны ажлынх нь зардал нь хасагдчихсан байгаа.

Ч.Ундрам: Үйл ажиллагааны зардлуудаа танасан юм байна тэ? Ер нь 1.2 чинь.

Б.Лхагвасүрэн: Тамгын газрын хувьд болохоор зэрэг тээвэр шатахуун болон хангамж материалын зардлаас хасагдсан байгаа.

Ч.Ундрам: Цэдэвсүрэн дарга нэмж хариулах уу? Нэг номер нэмж хариулъя.

Л.Цэдэвсүрэн: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь төрийн албаны хуульд зааснаар энэ төрийн албан хаагчийн цалин хөлстэй холбоотой асуудлаар манай байгууллагаас санал авдаг.

Тэгэхдээ өнөөдөр хэлэлцэж байгаа энэ асуудал 2026 оны тодотгол буюу өмнө нь батлагдсан төсөв дээр дутагдаад байгаа хөрөнгийн асуудал. Бид нар Сангийн яам болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхантай манайхаас яг албан ёсоор бичгээр санал аваагүй ч ер нь зөвшилцөөд багш эмч нарын энэ дутагдаад байгаа цалин хөлсийг тодотголоор олгох нь зүйтэй гэдэг гээд санал нэгдсэн. 2027 оны төсвийн төсөл дээр ер нь энэ цалин хөлсний нэгдмэл бодлогыг цэгцэлье янзалъя гэдэг дээр ямар ч байсан Засгийн газартай холбогдох яамдуудтай хамтраад ингээд ажиллаж байгаа. Энэ хуулийн төсөл бол удахгүй өргөн баригдаж төрийн албан хаагчдын цалин хөлсний нэгдмэл бодлого илүү сайжирна гэж бодоод төлөвлөөд ажиллаж байгаа. Маш их судалгааны ажлууд давхар хийгдэж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Манайх дүгнэлт гаргадаггүй гишүүн ээ. Манайх санал өгдөг. Тэгэхдээ саналаа өгөөд хаяхаасаа илүүтэй саналаа.

Ч.Ундрам: Болсон уу Батбаатар гишүүн тодруулах уу. Тодруулъя.

Б.Батбаатар: Яах вэ зарим хариултууд орж ирэхгүй л байгаад байна л даа. Тэгэхлээр тэр 1 зүйлийг асуучихъя. Би буруу харчихсан байж магадгүй гэж бодож асууж байгаа. Тэгэхдээ хэрвээ буруу хараагүй бол та нар техникийн алдаануудаа засах ёстой. Тэр 3 дугаар зүйлд 11 дүгээр зүйлийн 367 тэрбум 653.5 гээд байж байгаа. Энэ зөв үү буруу юу? Ингээд биччихсэн нь. Энэ чинь 11 дүгээр зүйл биш 9 дүгээр зүйлдээ орох ёстой биш үү.

Одоо дээрээс нь саяын энэ асуусан асуултад хариулагдаагүй хариултуудыг Байнгын хорооны ажлын алба цаасаар, бичгээр, файлаар хариултыг нь аваад өгүүлэх хэрэгтэй юм байна. Түрүүн бас Хэрлэн гишүүний бичгээр авъя гээд байдгийн учир шалтгаан энд байна. Нөгөө нэг ийм асуулт асуудаг.

Ч.Ундрам: Санжаадорж дарга та бичгээр энэ асуултуудад нь. Одоо хажууд нь суугаад тэр 3.11 эд нарыг нь хамт сууж байгаад тайлбарлаад хариултыг нь өгчих.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2020 оны төсвийн тодотголын төслүүдтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Батбаатар гишүүнээр тасаллаа. Болормаа гишүүн үг хэлье.

Б.Болормаа: Энд хэд хэдэн асуудлуудыг бид нар эрэмбэлж харах юм бол яахын аргагүй нэн тэргүүнд үнийн өсөлт байгаа. Өнөөдөр Эдийн засгийн байнгын хороо хуралдаагүй байгаа учир эдийн засагтай холбоотой асуудлыг энд нэгэнт ажлын хэсэг байгаа дээр ярихаас өөр аргагүй байна. Үнийн өсөлттэй яаж тэмцэх вэ гэдгийг Сангийн яамнаас асуухад ерөөсөө ганц хэлж байгаа юм нь энэ махны зоорь барих энэ хүнс ногооны зоорь барих гэж хэлээд байгаа юм л даа. Өнгөрсөн жилүүдэд ер нь зоорь байгаагүй учир махны үнэ ихэссэн биш шүү дээ. Юу өөрчлөгдөөд энэ хүнсний инфляцаа алдчихав гэдгийг аягүй сайн бодоорой. Энэ махны экспортын квот гэдэг зүйл байхгүй болсон. Мах тодорхой хэмжээгээр үнэтэй байх нь зөв. Малчдад энэ таатай. Гэхдээ нөгөө талаараа иргэдийн орлого ямар байна түүнтэй харьцуулсан нэн шаардлагатай энэ махны үнэ хэр байна гэдэг энэ яг тэнцвэрт тооцоогоо олох ёстой. Эрэлт нийлүүлэлтээ бид нар бодох ёстой. Энэ хавар махны үнэ нэмэгдэхэд бүгд л би лав хөдөө орон нутагт байгаа малчидтай ярьж үзлээ, ченж нартай ярьж үзлээ. Бүх л хүмүүстэй ярьж үзэхэд намар хямдхан мал авсан. Махаа зарсан, тэд нар бүгдээрээ л урагшаагаа Хятад руу гарчихсан шүү дээ. Тэгээд хавар махны үнэ нэмэгдсэн шүү дээ гэж байгаа юм.

Яах вэ улс төрийн зорилгоор янз бүрээр махны үнэ нэмэгдсэн шалтгаанаа хэлж болно оо. Гэхдээ үндсэн асуудлаа шийдэхийн тулд яг яагаад энэ үнэ нэмэгдсэн юм, яагаад инфляцыг нь өдөөгөөд байна вэ гэдэг энэ бүх оношоо зөв тавиарай. Оношоо буруу тавиад тэрэндээ зориулсан буруу шийдэл гаргаад энэ махны зоориудыг барилаа гээд махны үнэ буурахгүй шүү дээ. Буруу онош тавьчихсан юм чинь энэ шийдэл чинь үр дүндээ хүрэхгүй байх вий.

Тэгэхээр Засгийн газар энэ дээр маш хариуцлагатай хандмаар байна аа. Энэ бүх янз бүрийн төсөл хөтөлбөр энэ болгоноос чинь хамгийн чухал юм чинь ерөөсөө энэ үнийн өсөлт шүү дээ. Энийгээ барьж чадахгүй араас нь цалин тэтгэвэр нэмэхээс өөр аргагүй болоод л ингээд л хөөрөгдөлд ороод л тэр нь төрийн албаны энэ нийт хөдөлмөр эрхлэгчдийн 20, 30 хувьд нь л нөлөөлж байгаа.

Бусад 60, 70 хувь нь карманаас нь мөнгө алга болж байгаа мэт л ийм зүйл болж байгаа. Тэгэхээр энэ төсвийн тодотголын би нэн шаардлагатай юм энэ инфляцтайгаа л ямар арга хэмжээ авах вэ гэдэг л байх болов уу гэж бодож байна аа. Тэгэхээр энэ дээрээ нэгэнт Эдийн засгийн байнгын хороо хуралдаагүй юм чинь энд холбогдох хүмүүст нь хэлье гэж бодож байна.

Хоёрт энэ гадаад зээллэгийн таазыг ярьж байна. Сая Сангийн яамны хүн хэлж байна л даа. Улсын Их Хурал бол энэ эрхийг олгодог оо. Тэгэхээр энэ эрхийг олох эсэхийнхээ наана би яг юунд шаардаад яагаад энийг асуугаад байна гэхээр юунд зарцуулах гээд байгаа гэдгийг нь мэдэх гээд байна шүү дээ. Тэрийгээ нууж хааж байгаа мэт иймэрхүү байдлаар хариулт өгөхгүй ээ. Бид нар энэ гадаад зээлийн чинь дээд хэмжээг олгохдоо юунд олгох гээд байгаа юм гэдгийг чинь багцааг нь авч Улсын Их Хурал энэ төсвийг батлах уу, үгүй юу тодотголыг батлах уу, үгүй юу гэдгийг энд хэлэлцээд сууж байна шүү дээ.

Тэгэхээр энэ хариулт ерөөсөө хангалтгүй байна аа. Тэгэхээр энэ зээллэгийн асуудал дээр онцгойлон анхаарч онцгойлон дэлгэрэнгүй хариулт өгмөөр байна. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хэлж байгаа эрсдэлүүдийг хаах механизмууд хангалтгүй.

Ч.Ундрам: Тулгаа дарга хариулт хангалтгүй гэсэн учраас та нэмж хариултаа бичгээр Болормаа гишүүнд хүргүүлээрэй. Алтангэрэл гишүүн үг хэлье.

О.Алтангэрэл: Энэ цалин хөлсний тогтолцооны талаар Улсын Их Хурлын гишүүдийн ярьж байгаа асууж байгаа тал дээр сая манай Сангийн яам хариулж байна. Төрийн албаны зөвлөл маань хариулж байна. Тэгээд яг энэ асуудлуудаа хийгээрэй манайхан. Дараа дараагийн удаад бид нар энийг чинь асууна шүү. Яагаад гэвэл энэ Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бид нар энэ төрийн албан хаагчдын асуудлыг бид нар ярихаас аргагүй болчхоод байгаа юм. Энэ шударга бус байдлыг бид нар залруулахаас аргагүй болчхоод байгаа юм. Тэгээд энэн дээр ямарваа нэг албан тушаалтан нам эвсэл элдэв юм үл харгалзаж бусад нөлөөллийг үл харгалзаж хуулийн дагуу хичээж сайхан ажиллацгаагаарай манайхан. Би Төрийн албаны зөвлөлийн дарга би ажлаа сайн мэдэж байна гэж дүгнэлээ. Тооцоо судалгаа нь байна, арга замынхаа талаар өөрөө ярьж байна. Энэ юмаа зоригтой сайхан хийгээрэй.

Бид нар яг ингээд хариуцсан салбар салбартаа зориг гаргаж шийдэл гаргаж ажиллахгүй бол асуудлууд маань хуримтлагдаад жил болгон бид нар нэг ийм төсвийн тодотголын үеэр төсвийн үеэр ярьдаг асуудлууд нөгөө л нэг асуудлуудаа ярьдаг. Дахиад л нэг ийм ийм ч хууль санаачлах гэж байгаа ийм ч юм хийх гэж байгаа гэдэг нэг зүйл рүү заадаг. Бодитой үр дүн нь харагддаггүй ийм байдалтай байгаад байна шүү.

Тийм учраас энэ асуудлаа нэн даруй шийдээрэй. Нэн ялангуяа тэр удирдах албан тушаалд томилогдчихсон тэр шаардлага хангахгүй байгаа хүмүүсийн асуудлыг шийдмээр байна аа. Та бүхэн санаачилгатай ажиллаж байгаа юм байна аа. Тэгээд энэ дээр хууль тогтоомж болоод бодлогын хувьд асуудал байвал чөлөөтэй тавиарай. Бид энд асуудлыг дандаа шүүмжлэхийн тулд биш, засахын тулд бодлогыг зөв чигт нь оруулахын тулд сууж байгаа хүмүүс гэдэг утгаараа ийм санаа санаачилга гаргасан. Шударга ёсны төлөөх ажлыг дэмжих үүрэгтэй гэж ингэж ойлгож байгаа.

Тийм учраас энэ асуудлуудаа тавиарай. Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл. Тэр Нийслэлийн Засаг дарга гэхээр л олддоггүй үзэгддэггүй тийм тэнгэрийн хүн биш шүү. Түрүү түрүүчийн НЗД нар энэчээ асуудлаа яриад ажлаа яриад суугаад явж байсан жишигтэй шүү. Тэгээд асуудлаа шийдүүлээд явдаг, энэчээ асуудлаа ярьдаг ийм жишигтэй шүү. Тэгээд Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаа явуулж байхад ямарваа нэг аян шалтаг тоочдог. Энэ хуралдаанд оролцдоггүй, эрэмбийн асуудал гэж нэг зүйл байдаг юм шүү. Тэр нийслэл дээр болж байгаа хурлын чинь эрэмбэ чухал юм уу, Монгол Улсын Их Хурал дээр явж байгаа Байнгын хороон дээр асуудлаа танилцуулаад явж байгаа асуудал чинь чухал юм уу гэж эрэмбэлээрэй нийслэлийнхэн. Ер нь ийм хандлагууд ер нь цухалзаад харагдаад байгаа. Тэрүүгээр түүгээрээ болгочихдог, түүгээрээ шийдчихдэг гэдэг ийм хандлага цухалзаад байгаа шүү. Тийм юм байхгүй. Бид Үндсэн хуулиараа нэгдмэл улс учраас асуудлаа энд ярьж энд шийдүүлж танилцуулж явах үүрэг чинь та нарт байгаа шүү гэдгийг нийслэлийнхэнд сануулъя.

Тэгээд СЕХ-ныхон маань нэлээн шахуу ажиллаж байгаа юм байна аа. Тэгэхээр энэ сонгууль зохион байгуулахтай холбоотой асуудал дээрээ тулгамдсан асуудал юм байвал цаг тухайд нь энэ ТББХ-нд асуудлаа тавьж шийдүүлж байх ёстой шүү. Бид бас энийг Монгол төрийн сонгууль шударга явагдах ёстой хэвийн явагдах ёстой учраас дэмжих ийм чиг үүрэгтэй байгаа. Тэгээд энэ аудитын даргыг төрийн хяналтын томоохон чиг үүрэг хэрэгжүүлж байгаа албан тушаалтны хувьд элдэв бөөрөнхийлөлгүй яг шийдэх гэж байгаа асуудалдаа тууштай хуулийн талд хариулж байгаад талархъя. Тэгээд өнөөдрийн Байнгын хороон дээр ярьж байгаа, төлөвлөж байгаа ажлуудаа бүгдээрээ бас хуульд нийцүүлэн зоригтойгоор шийдэж хийгээрэй гэж хүсье. Баярлалаа та бүхэнд.

Ч.Ундрам: Энэ улсын төсөв ярьж байхад бүх нэгжийн удирдлагууд ирсэн байх ёстой. Тэгэхээр дараа дараагийн хурал дээр энэ НЗД ядаж орлогч дарга нь ирэх ёстой шүү. Энийг дамжуулж хэлээрэй. Өмнөх энэ төсөв хэлж байх үед дандаа байдаг байсан шүү. Энийг анхааруулмаар байна. Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Төрийн байгуулалтын байнгын хороо өөрийнх нь эрх асуудлын хүрээнд энэ тодотголтой холбоотой 3 зүйл ерөнхийд нь анхааруулаад хэлчихье гэж бодож байна аа. Энэ дэгийн асуудал байна. Орон нутаг байна, төрийн алба байна.

Дэгийн асуудал дээр бид нар нөгөө 3 сан маань улсын төсөвтөө тодорхойлолтодоо багтаж явж байна гэж бодоод ойлгоод ингээд хэлэлцэж байна гэж харж байна. Хэрвээ тухайн жилийн Төсвийн тухай хууль гэдэг 72.3-аар дэгээрээ явах юм бол бид нар бас 5.1-ээрээ ТББХ дэгээр зохицуулаагүй асуудал дээр хэрхэн хэлэлцүүлэх вэ гэдгийг бас гаргаж тавих ёстой байх. Хэрвээ тэгэх шаардлагагүй гэж үзэж байгаа бол энэ дээрээ нэг анхаараад анзаарчихна биз дээ Их Хурлын Тамгын газар. Орон нутаг түрүүн тэр асуултуудад яваад байгаа. Дундговийн санхүүгийн дэмжлэг 38 дахин, Ховдынх 15 дахин өсөж байна гээд дэмжлэг төсвөөс. Сая ингээд ирээд Сангийн яамны зүгээс өгч байгаа хариултаар бол түрүүн урьд нь би сонсож чадахгүй байгаад байсан юм. Сая ингээд өгч байсан өгч байгаа хариултаар ерөөсөө л Ховдод нэг компани татвар төвлөрүүлэх орлого нь байхгүй болсон, Дундговьд нэг компани байхгүй болсон. Хоёрхон компаниас болоод л энэ төсвийн тодотгол дээр нийт дүнгээрээ 20 хэдэн тэрбум хэд болж байлаа даа. Нийт дүнгээрээ. Ийм хэмжээний өөрчлөлт орж байна. Энэ нөгөө бид нарын төсөв хэлэлцэж батлахдаа орон нутгийн төсвийг тэр орон нутаг хамаагүй. Орон нутаг өөрөө зохицуулалтаа

хийнэ. Бид нар энийг нь зааж өгч байгаа юм гээд. Одоо энэ чуулган дээр ч гэсэн Ерөнхий сайд, Сангийн сайд нарын тайлбарлаад байсан зүйл маань энэ төсвийн тодотголоороо өөрөө бас буруу явж байна гэдгийг харуулж байгаа юм аа.

Тийм болохоор бид нар энэ тогтолцооны гэдэг юм уу энэ яаж зохицуулалтаа хийдэг байх ёстой юм бэ орлого нь тасарч байх зарцуулалтаа яаж ингээд эрхүүдийг нь нээж байна вэ гэдэг зүйлээ анхаарах ёстой. Өмнөговийнх ч гэсэн орлогын албан татвар нь буурсан. 155 тэрбум төгрөгөөр бид нар ингээд төсөвтөө өөрчлөлт хийгээд сууж байна. Төрийн албаны үндсэн цалин төсвийн 85 хувиа зарцуулаад дуусчихсан. Тэгээд үлдэгдлийг нь одоо зарцуулах гээд үндсэндээ 9 сар цаана нь 3 сарын хугацаан дотор энэ чинь тэр чигээрээ өр болж байгаа шүү дээ. Энийгээ өөрчлөлтийг нь хийхгүй бол одоо ингээд хэд хоногийн дараанаас төрийн бүх албан хаагч нар цалин авах тэр төсөв байхгүй болчихно оо гээд цалин нь хаагдчихна л гэж ингэж ойлгоод байгаа юм.

Тэгэхээр төсвийн тодотгол төсвөө баталж байгаа байдал оруулж ирж байгаа тайлбар, танилцуулга энэ бүх юмаа илүү тодорхой болгохгүй бол ингээд нэг асуулт асуудаг. Хариулт нь нэг тийм хайрцгийн хүрээнд хэлчихдэг нэг хуулийн хүрээнд ингэж хариулахад бол сайдах муудах зөв буруу болох хамаагүй ингээд хариулт нь ханачихна гэдэг байдлаар яваад байгаад анхаармаар байгаа юм.

Дээрээс нь улсын нэгдсэн төсөв хэлэлцэж байхад аль ч шатны засаг захиргааны ажилтан шаардлагатай хүмүүс нь ирээд суудаг байх хэрэгтэй. Хэрэгтэй хэрэггүй буюу асуултад хариулахгүй мэргэжилтнүүдээ дагуулж ирдгээ болих хэрэгтэй. Тэр газар, газрын дарга, төрийн нарийн, дэд сайд, сайд нар нь ирээд суудаг. Бид нар чинь нэг тиймэрхүү дэг, хуультай байх.

Улсын Их Хурлын өмнө бол сайд нар хариуцлагаа хүлээдэг. Засгийн газар Ерөнхий сайдынхаа өмнө. Тийм болохоор ийм зүйлүүдээ бодож энэ танилцуулгуудыг ер нь жаахан нэмж өгөхгүй бол сая л Санжаа даргын хэлж байгаагаар сая л эхний хариултаа анх удаа олж авлаа шүү дээ. 2, 3 асууж байгаад яагаад энэ төсөв өөрчлөгдөж байна. Тэгсэн 1 компанийн өөрчлөлтөөс болоод л. Тэгээд энэ хүмүүс маань.

Ч.Ундрам: Гишүүд үг хэлж дууслаа. Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Хэлэлцүүлэг хийсэн талаарх танилцуулгаа Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

15.54 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА